

УБ хотын ХЭХТөвийн харьяа “ИВЭЭЛ” МХБүлгийн 2022 оны үйл ажиллагааны тайлан

“ИВЭЭЛ” МХБүлэг нь 2005.09.10 нд байгуулагдсан.8-н гишүүнтэй. Сарын хуримтлал 20,000 төг.17 жил тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж байна.

ЗОРИЛГО: Гишүүд сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж бие биенээ итгэж , хүндэлж идэвхи санаачлагатайгаар хамтран ажиллахад оршино.

Бидний уриа: Бүтээнэ гэсэн нэгхэн хүслээрээ
Бүхий л амьдралаа гэрэлтүүлж
Болгоно гэсэн гэгээн сэтгэлээрээ
Босго нь өндөр амжилт руу тэмүүлж явцгаая

“ИВЭЭЛ” бүлгийн дотоод журмаас...

- Гишүүдийн бүлэгт орох гарах эрх нь нээлттэй
- Гишүүд аливаа зүйлд цаг баримталдаг байх
- Сар бүр тогтмол хурлаа хийж санал бодлоо хуваалцаж ярилцах
- Гишүүд нэг нэгэндээ эелдэг,итгэлтэй ,хяналттай зарим тохиолдолд шаардлага тавьдаг байх
- Бүлгийн сангаас зээл авах эрхтэй
- Жилд нэг удаа кампанит ажил зохион байгуулах
- Гишүүд зээл авахад бүрдүүлэх зүйлс (Зээл хүссэн өргөдлөө бичиж гишүүдийн гарын үсгээр баталгаажсан байна.Барьцаа хөрөнгө)
- Гадны иргэдэд зээл гаргахад бүрдүүлэх материал 1.Зээл хүссэн өргөдлөө бичиж тус бүлгийн гишүүдийн гарын үсгээр баталгаажсан. 2.Иргэний үнэмлэхээ натариотоор батлуулсан байх 3.Барьцаа хөрөнгө тавих 4.Зээл хүсэгч өөрийн биеэр ирж бүлгийн хуралд суух
- Гишүүд болон гадны иргэд зээлийн графикт хугацааг хэтэрүүлсэн тохиолдолд хоног тутамд **0,5%-ийн** алданги тооцно.

“ИВЭЭЛ” МХБүлэг нь сар бүрийн 5-20 ны хооронд хурлаа тогтмол хийж санал бодлоо солилцож гишүүдэд тулгамдаж буй асуудлуудыг нь ярилцаж шийдвэр гаргадаг.Хурлаа гишүүдийнхээ гэрээр ээлжлэн хийдэг.Хурлын ирц 80-100 %-ийн ирцтэй хуралддаг.

2022 оны 2-р сарын хурлаа хамгийн өндөр настай Д.Лхагваа эгчийнд хийсэн.



Бүлгийн гишүүд 2022 оны 3-р сараас хоёрдогч түүхий эд болох (шил, лааз, хуванцар сав) цуглуулж түүхий эдийн цэгт өгч түүнээсээ бүлэгтээ орлого оруулдаг

“ИВЭЭЛ” МХБүлгийн 2022 онд хийгдэх ажлын төлөвлөгөө

| № | Хийгдэх ажлууд | Хугацаа | Хариуцах эзэн | Үр дүн |
|---|----------------------------|-------------------|--------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Бүлгийн хуримтлалыг өсгөх | Жил бүр | Бүлгийн гишүүд | Гишүүн бүр хоёрдогч түүхий эд цуглуулж бүлэгтээ орлого оруулна.Бүлгийн хуримтлал сардаа 1000-3000 төгрөгөөр буюу 2-4%-иар өсгөнө. |
| 2 | Жимс нарийн ногоо Тарих | 4-20 оос 6-10 | Бүлгийн гишүүд | Гишүүд хаашаандаа мод хүнсний ногоо,жимс тарьж өөрсдийнхөө хүнсний хэрэгцээ хангахын зэрэгцээ зах зээлд худалдан борлуулж орлого нь нэмэгдэнэ. |
| 3 | Сайн үйлсийн аян | 1-р сард | Бүлгийн ахлагч С.Сарангэрэл | ХУД”ийн 6-р хорооны дарга болон халамжийн ажилтантай хамтарч нэг өрх айлд тусламж үзүүлнэ.Энэхүү тусламж нь тухайн айлын амьдралд тус нэмэр болно. |
| 4 | Туришлага солилцох уулзалт | 2022 оны 7-р сард | Бүлгийн гишүүд | Жил бүр зохион байгуулагддаг хот хөдөөгийн МХБХолбооны гишүүдийн ТСУулзалтаас олон сайхан мэдээлэл,туришлага,үр |

| | | | | |
|---|---------------------------------------|----------------------|---------------------------------------|----------------------------------------------------------------------------------------|
| | | | | <i>өгөөжтэй санаануудыг мэдэж авч бүлэгтээ хэрэгжүүлэн ажилладаг.</i> |
| 5 | <i>ОУАЭХамгаалах өдрийг тэмдэглэх</i> | <i>10-р сарын 01</i> | <i>Хяналтын зөвлөл Д.Сарангуа</i> | <i>Хорооныхоо ахмадын зөвлөлтэй хамтарч үр өгөөжтэй ажил зохион байгуулж ажиллана.</i> |
| 6 | <i>ОУХЭХамгаалах өдрийг тэмдэглэх</i> | <i>12-р сарын 10</i> | <i>Бүлгийн гишүүд</i> | <i>Бүлгийн гишүүд ХЭХТөвтэй хамтран ажиллана.</i> |

“ИВЭЭЛ” бүлгийн гишүүд Хан-уул дүүргийн 7-р хорооны хэсгийн ахлагч, халамжийн ажилтантай хамтарч 2022 оны 04 сарын 14 нд Хан-уул дүүргийн 7-р хороонд оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй, сахарын өвчтэй өрх толгойлсон эмэгтэйд нүүрс мод болон хүнсний бүтээгдхүүнээр сэтгэлийн хандив өргөлөө.



2022 оны 03-р сард тус бүлгийн гишүүд сарын хуримтлал 20,000 төгрөг болсон. 2022.05-р сард тус бүлэгт нэг гишүүн шинээр орсон . ” ИВЭЭЛ”бүлгийн 05-р сарын хурал



ХЭХТөвийн дэргэдэх “Тэгш боломж”ХЗХоршооноос “Тэр бум мод”төслийн хүрээнд тус бүлгийн гишүүдэд үнэгүй монос,үхрийн нүд,тэхий шээг зэрэг модны суулгац өгсөн.



Бүлгийн.гишүүн Д.Сарангуа,С.Сарангэрэл нар өгсөн суулгацаа тарьсан нь.

ХЭХТ-ийн харьяа МХБХолбооны гишүүдийн Туршлага солилцох уулзалт



2022.08.05-15 хүртэл Баруун аймгуудын үзэсгэлэнт газруудаар аялсан.



2022 оны 08 р сарын 30 нд “Тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн үнэлгээ”


Үндэсний хэлэлцүүлэг

“ИВЭЭЛ” МХБүлгийн гишүүн Д.Сарангуа оролцсон. Тус хэлэлцүүлгээр тогтвортой хөгжлийн зорилтуудын талаар санал бодлоо солилцож маш үр дүнтэй хэлэлцүүлэг болсон. 17-н зорилтуудаар хэлэлцүүлэг өрнүүлсэн тэр дундаа 1,2,3,4 –р зорилтуудаар санал зөвлөмж арай түлхүү гарч байсан.



2022 оны 09 сарын 10-13 ныг хүртэл Дорнод аймгийн Баян-дун суманд **“Нөлөөлөл ба оролцоо” манлайлагч эмэгтэйчүүдийн сургалт, “Иргэдийн оролцоог хөгжүүлэе”, “Үндэсний түвшинд нөлөөлөх кампанит ажил”** манлайлагч эмэгтэйчүүдийн цуглаан зэрэг сэдэвт ярилцлага, хэлэлцүүлэг өрнүүлж санал бодлоо солилцов. тус суман дахь МХБХолбооны гишүүд, иргэд, төрийн албан хаагчид зэрэг 30 гаруй хүн маш идэвхитэй оролцсон. Оролцсон хүмүүсийн ихэнх нь залуучууд байсан нь онцлогтой байлаа. Орой нь **“Манлайлагч эмэгтэйчүүдийн цуглаан”** зохион байгуулж явуулахад 70-80 иргэд оролцож тоглоом тоглуулж, сугалаа явуулж буриад хувцасаараа жигдэрч “Эв нэгдлийн бүжиг” буюу ёохор хатирлаа. “ИВЭЭЛ” МХБүлгийн гишүүн Д.Сарангуа оролцож санал бодлоо солилцсон.





Улс оронд "Хөгжлийн эрэл тээвэр" тулалдсан асуултууд

1. Авшиа, хэлт түүх
2. Ажиллагааг эргэлт, 6 Ж.Хүрээхүүний хэлт тээвэр
3. Хүний эрхийн зорил, үр хэлт эргэлт нийцэлт байна
4. Урсгалд эхлэлт хуви, санхүүжилт, батлах, хэрэгжилтээр хяналт тавих
5. Эрүүр итгэлийг урсгалд эргэлтээр үзэлтэй дэмжлэгтэй байх
6. Зингэлээр үйлчилгээг боловсруулж дээшлүүлж / гуртгэлтэй /
7. Хөгжлийн эрэл тулалд итгэлтэй болговон хуви, төдөгөрлийн амьдрал эрлийг нөхдлийг хийжээ
8. Цахил эрлийн тулалд эргэлтээр хяналттай байх, дээшлэх
9. Эрүүр баталалт хуви
10. Хөгжлийн эрлийн амьдралд эргэлтээр хуви



2022оны 09 р сарын 15 нд Дорнод аймгийн Чойбалсан хотод “Иргэдийн оролцоог хөгжүүлэ” сэдэвт хэлэлцүүлэг боллоо.МХБХолбооны гишүүд болон иргэдийн төлөөлөл 50 гаруй хүний бүрэлдхүүнтэй хэлэлцүүлэг хийв.Хэлэлцүүлэгт иргэд идэвхитэй оролцлоо.



Хэлэлцүүлгийн дараа Б.Нарангэрэл даргатай МХБХолбооны байраар орж үйл ажиллагаатай танилцлаа.





МХБХолбооны гишүүдтэйгээ Дорнод аймгийн цэцэрлэгт хүрээлэн орлоо.




2022.07сарын 29-31 ны өдрүүдэд Монфемнет үндэсний сүлжээ ТББайгуулгаас зохион байгуулсан “Эмэгтэйчүүдийн эдийн засаг,эрх мэдэл”сэдэвт уулзалт хэлэлцүүлэг болж тус бүлгийн ахлагч С.Сарангэрэл оролцсон.



2022 оны 5-р сард тус бүлэгт орсон гишүүн В.Баярсайханы хувийн үйлдвэрлэл



Бүлгийн гишүүн Ч.Цэвэлмаа бүлгээсээ зээл авч гэрийнхээ хаалгыг шинэчилсэн нь.



Тус бүлгийн хуримтлалын данснаас 2022 онд гишүүд болон гадны иргэд давхардсан тоогоор 18 удаа **21,100,000** төгрөгний зээл авч амьдрал ахуйдаа зарцуулсан байна.

2022.12.03 нд “ИВЭЭЛ” МХБүлэг “Бидний хөгжил хамтын хүчээс” өдөрлөг болон шинэ жилээ тэмдэглэлээ. Тус өдөрлөгөөр 2022 оны тайлангаа танилцуулж 2023 онд хийгдэх ажлын төлөвлөгөөгөө ярилцаж санал бодлоо солилцож батлан гаргалаа. Мөн тэмцээн явуулж 3-н байр эзлүүлж гарын бэлгээр урамшууллаа.



ИВЭЭЛ МХБ-2022 ОН

